

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Сагсай сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2026/157/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баян-Өлгий аймаг

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл

Утас:99422227 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 99932710 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: Р.Содномдаржаа

Утас: 99101563 Цахим хаяг: Uujimaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

САГСАЙ СУМЫН ХҮҮХДИЙН
2 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б.ЗОЯ ТАНАА

АДБ.ОД.24 № 101
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сагсай сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сагсай сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сагсай сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэг нь 2025 онд 1,080.8 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 1,078.3 сая төгрөг зарцуулж, 99.8 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

837605000074

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,080,766,000.00	1,078,284,127.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,080,766,000.00	1,078,284,127.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,080,766,000.00	1,078,284,127.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	845,615,900.00	845,615,899.12
210101	Үндсэн цалин	539,779,400.00	539,779,400.00
210102	Нэмэгдэл	289,201,900.00	285,241,899.12
210103	Унаа хоолны хөнгөлөлт		3,960,000.00
210104	Урамшуулал	16,634,600.00	16,634,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,129,800.00	105,129,800.00
210201	Тэтгэврийн даатгал	71,305,300.00	71,305,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,456,200.00	8,456,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,228,000.00	4,228,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,228,000.00	4,228,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,912,300.00	16,912,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,961,400.00	48,870,682.00
210301	Гэрэл, цахилгаан	3,075,000.00	6,240,000.00
210302	Түлш, халаалт	46,886,400.00	42,630,682.00
2105	Нормативт зардал	56,040,100.00	55,257,480.00
210502	Хоол, хүнс	56,040,100.00	55,257,480.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	905,500.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	905,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,551,900.00	3,476,646.40
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,551,900.00	3,476,646.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,466,900.00	19,028,120.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,389,400.00	12,950,620.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,077,500.00	6,077,500.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,080,766,000.00	1,000,533,882.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	951,436,800.00	950,757,700.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	951,436,800.00	950,757,700.00

Сагсай сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	50,961,400.00	49,776,182.00
132001	Орон нутгийн төсвөөс	50,961,400.00	49,776,182.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	78,367,800.00	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	78,367,800.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		81,565,446.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		3,815,200.48
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	37.00	37.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00
620003	Үйлчлэх ажилтан	19.00	19.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	37.00	37.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	18.00	18.00
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	1.00	1.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1.00	1.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	17.00	17.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 145.7 сая төгрөгийн алдаа¹ илэрч, аудитын явцад 145.7 сая төгрөгийн алдааг залруулсан. *Залруулсан алдаа:*

- Санхүүгийн үр дүнгийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийн 1.2 сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд оруулан тайлагнасан.
- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн эх үүсвэрт улсын төсвийн санхүүжилтийг 0.6 сая төгрөгөөр дутуу, орон нутгийн төсвийн санхүүжилтийн 50.9 сая төгрөгийг, урьд оны үлдэгдлээс санхүүжих эх үүсвэрийг 78.4 сая төгрөгийг тусгаагүй, зарлагын төлөвлөгөөний дүнг 1.3 сая төгрөгөөр буруу тайлагнасан, төвлөрүүлэх шилжүүлгийн 1.2 сая төгрөгийг цэвэрлээгүй тайлагнасныг тус тус залруулав.
- Өмнөх жилүүдэд газар эзэмших эрхийг буруу бүртгэсэн байсаныг өмчийн өөрчлөлтийн тайланд Засгийн газрын оруулсан капитал дансанд 12.0 төгрөгөөр нэмэгдүүлж, өмнөх үеийн үр дүнгээс буруулж нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлтөөр залруулга хийлгэв.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Зөвлөмж

Аудитаар 10.8 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгөв.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалт, хяналттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Бараа үйлчилгээний бусад зардлын төсвөөс тээвэр шатахууны зардалд 5.6 сая төгрөгийг аймагт ажлаар, албан томилолт зэрэгт анхан шатны баримт бүрдэлт дутуу баримтаар зарцуулж, тооцоог зохих журмаар хийгээгүй, төсвийн зарцуулалтад зохих журмаар хяналтыг тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 14 дүгээр зүйлийн 14.3-д “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ”, 14.3.1-д “анхан шатны баримт бүрдүүлэх”, 20.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч мэргэжлийн ур чадвар, ёс зүйтэй байх бөгөөд дараах бүрэн эрхтэй байна”, 20.1.1-д “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах”, 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримт бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах, зөрчлийг цаашид давтан гаргахгүй байхыг зөвлөмж болгов.

2.1. Илрүүлэлт:

Цалингийн зардлын төсвөөс унаа, хоолны хөнгөлөлтөд нэг өдрийн 5.0 мянган төгрөгөөр бодож нийтдээ 18.5 сая төгрөг олгосон бөгөөд үүнтэй холбоотой цалингийн татвар, нийгмийн даатгалын шимтгэлд 5.2 сая төгрөгийн өглөгийг шинээр үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Боловсролын сайдын 2025 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 1/554 дүгээр албан бичгээр өгсөн “цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн төрийн албан хаагчид олгох хоолны зардлыг 2025 оны төсөвт багтаан хэрэгжүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Шинээр үүссэн өр төлбөрийг 2026 онд багтаан бүрэн барагдуулах, нэмж өр үүсгэхгүй байхыг зөвлөмж болгов.

Сагсай сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан зөрүүтэй тайлагнасан	1	132,483.5			1	132,483.5	1	132,483.5				
Санхүүгийн үр дүнгийн тайланд зөрүүтэй тайлагнасан	1	1,185.2			1	1,185.2	1	1,185.2				
Өмчийн өөрчлөлтийн тайлан буруу бүртгэж тайлагнасан	1	12,000.0			1	12,000.0	1	12,000.0				
Дүн	3	145,668.7			3	145,668.7	3	145,668.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Тээвэр шатахууны зардалд тооцоог зохих журмаар хийгээгүй, төсвийн зарцуулалтад зохих журмаар хяналтыг тавьж ажиллаагүй байна	1	5,576.2					1	5,576.2					
Цалингийн татвар, нийгмийн даатгалын шимтгэлд 5.2 сая төгрөгийн өглөгийг шинээр үүсгэсэн	1	5225.0					1	5225.0					
Дүн	2	10,801.2					2	10,801.2					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								